

БАТЛАВ
МЭДЭЭГҮЙЖҮҮЛЭГЧ ЭМЧ НАРЫН
НИЙГЭМЛЭГ ТЭРГҮҮН



Б.ОДГЭРЭЛ

МЭДЭЭГҮЙЖҮҮЛЭГ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Нийгэмлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол идэвхи санаачилгатай оролцдог байх;
2. Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ сэтгүүл /хамгийн багадаа 1/ болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 2-оос доошгүй өгүүлэл /онолын, тойм ба судалгааны өгүүлэл/ нийтлүүлж, 5-с доошгүй илтгэл /онол практикийн хуралд/ хэлэлцүүлсэн байх; /өгүүлэл, илтгэлийн хуулбар/;
3. Гадаадад болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд мэдээгүйжүүлгээр мэргэшил дээшлүүлэх сургалтад 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх, түүнийг нотолсон баримтыг хавсаргах;
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэшлийн сургалтад тогтмол хамрагдсан байх /нийгэмлэгийн болон мэргэшлийн сургалтад оролцсон гэрчилгээний хуулбар хавсаргах/;
5. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх;
6. Мэргэшлээрээ ажилласан 8 жилд хийсэн ажлын тайлан–товч тоон үзүүлэлт.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Нийгэмлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол идэвхи санаачилгатай оролцдог байх;
2. Бүтээлийн жагсаалт гаргаж, өмнөх зэрэг хамгаалснаас хойш нийгэмлэгээс эрхлэн гаргадаг “Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ” сэтгүүлд /хамгийн багадаа 2/ болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 3-аас доошгүй өгүүлэл /онолын тойм ба судалгааны өгүүлэл/ нийтлүүлж, 5-аас доошгүй илтгэл /онол практикийн хуралд/ хэлэлцүүлсэн байх; /өгүүлэл, илтгэлийн эхийг хувиалан хавсаргана /;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

3. Гадаадад болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд мэдээгүйжүүлгээр мэргэшил дээшлүүлэх сургалтад 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх, түүнийг нотолсон баримтыг хавсаргах;
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэшлийн сургалтад тогтмол хамрагдсан байх – нийгэмлэгийн болон мэргэжлийн сургалтад оролцсон гэрчилгээний хуулбар;
5. Шинээр суралцагч эмч, эмнэлгийн мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг эзэмшүүлсэн, нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтад идэвхитэй оролцсон байх;
6. Залуу эмч, сувилагч нарт чиглэсэн сургалт зохион байгуулах эсвэл хичээл заасан байх /сургалтын хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах/ ;
7. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх;
8. Англи хэлний зохих мэдлэгтэй, түүнийг нотлох баримтыг /үнэмлэх, гэрчилгээ, мэргэжлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал/ хавсаргах;
9. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайланг товч тоон үзүүлэлтээр гаргах.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэдээгүйжүүлэг судлалаар тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш мэргэшлээрээ 5 ба түүнээс дээш, үндсэн мэргэшлээрээ 25 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх;
2. Сум дундын эмнэлэгт мэдээгүйжүүлгийн эмчээр тогтвор суурьшилтай, тасралтгүй 25 ба түүнээс дээш жил ажилласан, тусгай шалгуур хангасан бол зөвлөх зэрэг горилох;
3. Нийгэмлэгийн үлгэр жишээч гишүүн байх, үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, нийгэмлэгээс зохиосон сургалтын үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцсон байх;
4. Өмнөх зэрэг хамгаалснаас хойших бүтээлийн жагсаалт гаргах. Үүнд:
 - Нийгэмлэгээс эрхлэн гаргадаг “Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ” сэтгүүл /хамгийн багадаа 3/ болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 5-аас доошгүй өгүүлэл /онолын тойм ба судалгааны өгүүлэл/ нийтлүүлсэн байх;
 - 8-аас доошгүй илтгэл /онол практикийн хуралд/ хэлэлцүүлсэн байх; /өгүүлэл, илтгэлийн эхийн хуулбар хавсаргах/;
 - Өөрөө бичиж хэвлүүлсэн ном болон хамтран бүтээсэн номын тоо 2-оос доошгүй байх;
 - Боловсруулж баталгаажуулсан оношилгоо, эмчилгээний удирдамжийн тоо 2-оос доошгүй байх;
 - Зохиогчийн эрх, ашигтай загвар, оновчтой саналын гэрчилгээний аль нэгийг авсан байх;
 - Эмнэлзүйн практикт бодитоор нэвтрүүлж үр дүнгээ өгсөн шинэ арга 2-оос доошгүй байх;
5. Тусгай шалгуурыг хангасан, мэргэжлийн ажлаа чадварлаг, санаачилгатай гүйцэтгэж ирсэн, хамт олондоо хүндлэгдсэн, үлгэр жишээ ажиллаж байгаа,

6. зөвлөх зэргийн шалгалтад орохыг зөвшөөрсөн талаарх мэдээллийг байгууллагын тодорхойлолтод тусгасан байх;
7. Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд мэдээгүйжүүлгээр мэргэшил дээшлүүлэх сургалтад 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх, түүнийг нотолсон баримтыг хавсаргах;
8. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэшлийн сургалтад тогтмол хамрагдсан байх, нийгэмлэгийн болон мэргэшлийн сургалтад оролцсоны гэрчилгээний хуулбар хавсаргах;
9. Шинээр суралцсан эмч мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг эзэмшүүлсэн, залуу эмч, сувилагч нарт чиглэсэн сургалтад хичээл заасан байх; /сургалтын хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах/;
10. Мэргэшлээрээ зөвлөх, бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн, өөрийгөө орлох хэмжээний шавь нарыг бэлтгэсэн байх;
11. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх /англи хэлний зохих мэдлэгтэй, түүнийг нотлох баримт болох үнэмлэх, гэрчилгээ, мэргэшлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал хавсаргах/;
12. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайланг товч, тоон үзүүлэлтээр гаргах.